



СОНГОГДОХ ЭРХ
Нэр дэвшигч



Нэр дэвшигчид тавигдах шаардлага

- шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;
- ял шийтгэлгүй байх;
- цэргийн жинхэнэ хугацаат алба хаах насны иргэн (18-26 нас) цэргийн алба хаах үүргээ биелүүлсэн байх
- Тухайн аймаг, нийслэл, суманд 180-аас доошгүй хоног тасралтгүй, байнга оршин суугчаар бүртгэгдсэн байх
- Чөлөөлөгдөх албан тушаалтан хүсэлтээ өгсөн байх.



Нэр дэвшигчид тавигдах шаардлага

- Чөлөөлөгдөх албан тушаалтнууд:
 - 4 сарын 1-нээс өмнө ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн байх ба нэр дэвшигчээр бүртгүүлсэн өдрөөс хойш ажил, албан үүргээ гүйцэтгээгүй байвал зохино.
- Төрийн жинхэнэ албан хаагч сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших бол:
 - 3 сарын өмнө төрийн албанаас чөлөөлөгдөх өргөдлөө төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гаргана.



Хориглох зүйл

- Нэг намын гишүүнийг өөр намаас нэр дэвшүүлэх
- Орон нутгийн сонгуульд зэрэг, тухайн хурлын сонгуулийн нэгээс илүү тойрогт нэр дэвших
- Намын гишүүн бус иргэнийг түүний бичгээр гаргасан зөвшөөрөлгүй намаас нэр дэвшүүлэх
- Нөхөн нэр дэвшүүлэх.



Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл

- Нэр дэвшүүлэх ажиллагааг хуулийн хугацаанд явуулаагүй;
- Нэр дэвшигчид тавигдах шаардлага хангаагүй;
- Баримт бичиг дутуу, эсхүл хуурамч;
- Дэмжигчдийн гарын үсэг цуглуулахдаа хууль бус арга хэрэглэсэн.

(Сонгуулийн тухай хуулийн 158-р зүйл)



Нэр дэвшигчийн ҮНЭМЛЭХ ОЛГОХ

- Санал авах өдрөөс 22 хоногийн өмнө буюу **2016.9.27-ны** өдөр нэг өдөр олгоно.
- Нэр дэвшигчийн үнэмлэхийг нэр дэвшигчид өөрт нь, эсхүл төлөөлөгчид нь олгоно.



Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах үндэслэл

- Сонгуулийн тухай хуулийн 52, 67.3, 70.1, 70.5.1 – 70.5.10, 70.5.13-70.5.16-д заасан үндэслэл тогтоогдвол;
 - Нэр дэвшигч бүртгүүлсний дараа,
 - дүн гарсны дараа
 - төлөөлөгчийн бүрэн эрх хүлээн зөвшөөрөгдсөний дараа
- Шүүхийн шийдвэрийг үндэслэнэ.

(Сонгуулийн тухай хуулийн 159-р зүйл)



Нэр дэвшигчийг хасах

- Нэр дэвшигчээр бүртгүүлсний дараа **бүртгэхээс татгалзах үндэслэл бий** болбол бүртгэсэн сонгуулийн байгууллага нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас хасч, нийтэд мэдээлнэ.
- Бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдсөний дараа хасах тухай сонгуулийн хорооны шийдвэр гарсан бол тухай төлөөлөгчийн мандат нь хүчингүй болж, бүрэн эрх нь дуусгавар болно.



Нэр дэвшигчийг хассанаас үүсэх эрх зүйн үр дагавар

- Саналын хуудас хэвлэгдэхээс өмнө
 - саналын хуудаст нэрийг нь бичихгүй.
- Саналын хуудас хэвлэгдсэний дараа
 - саналын хуудсыг дахин хэвлэнэ
 - дахин хэвлэх боломжгүй бол хасагдсан нэр дэвшигчид өгсөн саналыг сонгуулийн дүнд оруулахгүй.



Нэр дэвшигчийг хассанаас үүсэх эрх зүйн үр дагавар

- Сонгуулийн дүн гарсны дараа
 - хамгийн олон санал авсан нэр дэвшигч хасагдсан бол дахин сонгууль явагдана.
- Төлөөлөгчийн бүрэн эрх хүлээн зөвшөөрөгдсөний дараа
 - дахин сонгууль явагдана.
- **ДАХИН СОНГУУЛЬ** явагдвал хасагдсан нэр дэвшигч нь:
 - 6 жил сонгуульд нэр дэвших болон төрийн албанд томилогдох, сонгогдох эрхээ алдана.
 - урьд явагдсан сонгуулийн сурталчилгааны болон зохион байгуулалтын бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.



www.gec.gov.mn